



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

1997 оны 3 дугаар
сарын 25 өдөр

Дугаар

6-44

Улаанбаатар
хот

Санхүүгийн хяналт шалгалтын албаны дүрэм батлах, ажилд томилох тухай

1. Монгол улсын Засгийн газрын 1996 оны 263 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 1997 оны Б/18 дугаар захирамжийг үндэслэн нийслэлийн Санхүүгийн хяналт шалгалтын албаны дүрмийг хавсралтаар баталсугай.

2. Нийслэлийн Санхүүгийн хяналт шалгалтын албаны даргаар Должинжавын Ургамалыг 1997 оны 03 дугаар сарын 01-нээс томилж, сарын үндсэн цалинг 34950 төгрөгөөр, нэмэгдлийг үндсэн цалингийн 60 хувиар бодож тогтоосугай.

3. Нийслэлийн Баянгол, Баянзүрх, Сонгино-Хайрхан, Сүхбаатар, Хан-уул, Чингэлтэй дүүрэгт Санхүүгийн хяналт шалгалтын тасгийг 6 хүртэл орон тооны хязгаартайгаар байгуулж 1997 оны 01 дүгээр сарын 16-наас тооцож ажиллуулахыг Санхүүгийн хяналт шалгалтын алба (н.Ургамал), дүүргийн Засаг дарга нарт зөвшөөрсүгэй.

4. Албаны албан хаагчдыг ажилд томилж, цалин нэмэгдлийг холбогдох журмын дагуу тогтоож ажиллахыг Санхүүгийн хяналт шалгалтын алба (н.Ургамал)-нд даалгасугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД
УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.НАРАНЦАЦРАЛТ

54



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН САНХҮҮГИЙН
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЛБАНЫ ДҮРӨМ

Нэг Нийтлэг үндэслэл

1.1 Монгол улсын Засгийн газрын 1996 оны 46 дугаар тогтоолоор баталсан санхүүгийн улсын хяналт шалгалтын дүрмийг мөрдлөг болгон Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд санхүүгийн хяналт шалгалтын ажлыг хэрэгжүүлэх аппарат нь Нийслэлийн Санхүүгийн хяналт шалгалтын алба мөн.

1.2 Алба нь Нийслэлийн Засаг дарга түүний Тамгын газрын харъяанд үйл ажиллагаагаа явуулж ажлаа тайлагнана.

1.3 Нийслэлийн Засаг даргын санхүүгийн хяналтын албаны зорилт нь улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөв, тусгай зориулалтын сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, Засгийн газрын шугамаар авсан зээл, туслам жийн хөрөнгийн ашиглалт, төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, төсөвт болон төсвийн санхүүжилт авдаг байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлан тооцоо, өмч хөрөнгийн ашиглалт, хам гаалалт, үр ашгийн байдлыг үндсэн баримтаар нь шалгаж үнэлэлт, дүгнэлт гарган илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулахад оршино.

1.4 Нийслэлийн хэмжээнд явуулах санхүүгийн хяналт шалгалтыг Санхүүгийн хяналт шалгалтын алба дүүргүүдийн санхүүгийн хяналт шалгалтын тасаг (тэдгээрийн улсын байцаагчид) хэрэгжүүлнэ.

Албаны бүтэц, зохион байгуулалт, орон тоог Нийслэлийн Засаг дарга батална. Санхүүгийн хяналт шалгалтын алба нь батлагдсан загвараар өөрийн тэм дэг хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

1.5 Нийслэлийн Засаг даргын Санхүүгийн хяналт шалгалтын албаны дарга нь Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч байна.

Албаны дарга, улсын ахлах байцаагчийг Нийслэлийн Засаг дарга Санхүүгийн улсын хяналт шалгалтын газартай зөвшилцөж томилж, чөлөөлөх бөгөөд улсын байцаагчийн эрхийг Сангийн сайд олгоно.

1.6 Нийслэлийн Засаг даргын Санхүүгийн хяналт шалгалтын албаны улсын байцаагчийг Нийслэлийн төрийн албаны салбар зөвлөлд танилцуулж, санхүүгийн хяналт шалгалтын албаны дарга томилж, чөлөөлөх бөгөөд тэдгээрт улсын байцаагчийн эрхийг Сангийн сайд олгоно.

1.7. Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн дээд, дунд боловсрол мэргэжилтэй, эзэмшсэн мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан байна.

Өмч хөрөнгийг ашиглан шамшигдуулсан, үрэгдүүлж шамшигдуулах боломж бололцоо олгосон нь хууль хяналтын байгууллагаар тогтоогдон ял шийтгэл, сахилгын арга хэмжээ авагдаж байсан буюу нягтлан бодогчийн мэргэжлээр ажиллах эрхээ хасуулж байсан хүмүүсийг Санхүүгийн хяналтын улсын байцаагчаар авч ажиллуулахыг хориглоно.

1.8. Санхүүгийн хяналт шалгалтын алба, санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчид үйл ажиллагаандаа Монгол улсын холбогдох хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр болон энэхүү дүрмийг удирдлага болгоно.

Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч, улсын байцаагч (цаашид энэ дүрэмд "улсын байцаагч" гэх) нь Засгийн газраас загварыг нь баталсан үнэмлэх, хувийн дугаар бүхий тэмдэг болон торгууль, шийтгэврийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

1.9. Нийслэлийн Засаг даргын Санхүүгийн хяналт шалгалтын алба нь дүүргүүдийн Санхүүгийн хяналт шалгалтын тасаг, улсын байцаагчийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, тэдгээрийн ажлыг шалгах, шалгалтын дүнг нэгтгэн дүгнэлт гаргах, шаардлагатай асуудлаар арга хэмжээний санал боловсруулж шийдвэрлүүлэх ажлыг хариуцан хэрэгжүүлнэ.

1.10. Санхүүгийн хяналт шалгалтын алба нь төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, төсөвт болон төсвийн санхүүжилт авдаг байгууллагаас бусад аж ахуйн нэгж байгууллагад өөрсдийнх нь хүсэлт, захиалгын дагуу шалгалтыг төлбөртэй хийж болно. Төлбөрийн хэм жээг Сангийн яамнаас тогтоосон жишгийг үндэслэн 2 талын гэрээний үндсэн дээр хариуцан тохиролцоно.

Хоёр. Санхүүгийн улсын хяналт шалгалтын чиглэл:

2.1. Санхүүгийн хяналт шалгалтыг дор дурдсан чиглэлээр хэрэгжүүлнэ.

а/Санхүү, төсвийн холбогдолтой хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр болон түүнийг үндэслэн төрийн захиргааны эрх бүхий байгууллагаас гаргасан журам, заавар, норм, хэмжээний хэрэгжилт.

б/Төсвийн хөрөнгийн зарцуулалт,

в/Төрийн өмчийн ашиглалт, зарцуулалт, хадгалалт, хамгаалалт,

г/Төсвийн орлого, зарлага, төрийн өмчтэй холбоотой анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт.

д/Төсвийн орлого, зарлагын төлөөлөлт, бүрдүүлэлт, төвлөрүүлэлт, татварын ноогдуулалт, төлөлт, түүнтэй холбогдсон бусад үйл ажиллагаа, түүний биелэлт.

е/Аж ахуйн нэгж нь хууль зүйн дагуу байгуулагдсан эсэх, үйл ажиллагаа нь зөвшөөрөгдсөн хүрээнд явагдаж байгаа эсэх.

ж/Тайлан, тэнцэл гаргалт, тушаалтын байдал.

з/Засгийн газрын тусгай зориулалтын сан, төсвөөс олгосон санхүүгийн тусламж, дэмжлэг, эргэж төлөгдөх нөхцөлөөр ашиглуулж байгаа төсвийн хөрөнгө, олон улсын байгууллага, гадаад орны Засгийн газар, байгууллага, иргэдээс олгосон зээл, өгсөн хандив, тусламж, тэдгээртэй адилтгах хөрөнгийн ашиглалт, зарцуулалт.

и/Төсвийн хөрөнгө оруулалтын ашиглалт, зарцуулалт

к/Төсвийн хөрөнгө, төрийн өмчийн ашиглалт, зарцуулалт, бүртгэлтэй холбогдсон бусад үйл ажиллагаа.

Гурав. Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчийн үүрэг, эрх:

3.1. Улсын байцаагч дор дурьдсан үүрэг гүйцэтгэнэ:

а/Энэ дүрмийн 10-р зүйлд заасан чиглэлийн дагуу улсын хяналт шалгалтыг хэрэгжүүлэх.

б/Хяналт шалгалтын тухай танилцуулга, бусад баримт бичгийг (нэгдсэн акт, нэг бүрчилсэн акт) зохих журмын дагуу үйлдэж, хяналт шалгалт хийсэн улсын байцаагч гарын үсэг зурах.

в/Хяналт шалгалтын акт, материалыг шалгуулсан өтгөөдэд танилцуулж, холбогдох баримт бичигт гарын үсэг зуруулах.

г/Хийсэн шалгалт, гаргасан дүгнэлт, бичсэн танилцуулга, акт, тоо баримтын үндэслэл, нотолгооны үнэн, зөвийг хариуцах.

д/Шалгалтын дүнгээр гаргасан шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж, түүнийг хангуулах арга хэмжээ авах.

е/Хяналт, шалгалт хийсэн байгууллага, аж ахуйн нэгжийн талаархи мэдээллийн нууцыг зохих хууль тогтоомжийн дагуу чанд хадгалах.

3.2. Улсын байцаагч дор дурьдсан эрх эдлэнэ:

а/Хяналт шалгалт хийх газар, байгууллагын үндсэн хөрөнгө, бараа материал, үнэт зүйлс, мөнгөн хөрөнгөд тооллого хийлгэж, тооцоо бодуулах.

б/Шаардлагатай үед зохих байгууллагуудтай тохиролцсоны үндсэн дээр холбогдох мэргэжлийн хүмүүсийг шалгалтанд татан оролцуулах.

в/Хууль, тогтоомж зөрчин улс, байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд учруулсан хохирол, төлөгдөөгүй, үндэслэлгүй тооцсон төлбөрт акт тогтоож төлүүлэх, шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг таслан зогсоох талаар холбогдох аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтанд хугацаатай үүрэг даалгавар өгч, биелэлтийг хангуулж, хариу авах.

г/Хяналт шалгалтын ажилд шаардлагатай мэдээ, судалгаа, тайлбар, тодорхойлолт, бусад баримт бичгийг холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтнаас үнэ төлбөргүй гаргуулан авах.

3.3. Улсын байцаагч нь хууль тогтоомж, дүрэм, журам зөрчсөн, тавьсан шаардлагыг биелүүлээгүй гэм буруутай этгээдэд төрийн Хяналт шалгалтын тухай, Захиргааны хариуцлагын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Валютын зохицуулалтын тухай, Банкны тухай хуулиуд болон санхүүгийн улсын хяналт шалгалтын дүрэм, бусад холбогдох хууль тогтоомжийн заалтыг үндэслэн захиргааны хариуцлага хүлээлгэнэ.

3.4. Санхүүгийн улсын хяналт шалгалтын алба, улсын байцаагчийн албан шаардлагыг байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, холбогдох иргэд тогтоосон хугацаанд нь биелүүлж, хариуг албан ёсоор өгч байх үүрэгтэй.

3.5. Шалгуулсан этгээд шалгалтын баримт бичигт заасан зүйлийг зөвшөөрөөгүй бол энэ тухай тайлбараа бичиж гарын үсэг зурна.

3.6. Шалгуулсан байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, улсын байцаагчийн гаргасан шийдвэр үндэслэлгүй гэж үзвэл гомдлоо шийдвэр гаргаснаас хойш 10 хоногийн дотор хяналт шалгалт хийсэн байгууллагын эрх баригчид тавьж болно.

Уг гомдлыг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ. Энэхүү шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо зохих журмын дагуу шүүхэд гаргаж болно.

3.7. Улсын байцаагч үүрэгт ажлаа зохих ёсоор биелүүлээгүй, хууль тогтоомж зөрчсөн бол түүнд холбогдох хууль тогтоомжинд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.